



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар #127

Чойбалсан

Г Хуваарь батлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны А/560 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Харьяа эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага болон иргэдийг хүлээн авч уулзах өдөр, хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

310422112

Эрүүл мэндийн газрын даргын... оны
11... дугаар сарын... ны/ний өдрийн
... дугаар/дүгээр тушаалын
хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Гараг	Ажил, үйлчилгээний төрөл
1	Даваа	Аймгийн Удирдах ажилтны шуурхай хуралд оролцох, аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэст эрүүл мэндийн салбарын асуудал, санал танилцуулах
		Байгууллагын шуурхай хурал
2	Мягмар	Харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудыг хүлээн авч уулзах, үүрэг чиглэл өгөх
		Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хүлээн авч уулзах, үүрэг чиглэл өгөх
3	Лхагва	Иргэдийг хүлээн авч уулзах
4	Пүрэв	Байгууллагын дотоод ажил зохион байгуулах
		Харьяа эрүүл мэндийн байгууллагууд дээр ажиллах
5	Баасан	Иргэдийг хүлээн авч уулзах